

Анги, бүлэг:

Шифр:

**8-Р АНГИЙН ФИЗИКИЙН ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН ДААЛГАВАР
ХУВИЛБАР “А”**

СОНГОХ даалгавар**Хугацаа 60мин**

1. Даралтыг ямар үсгээр тэмдэглэдэг вэ? /1 оноо/

- A. F B. P C. A D. S

2. Шахагдсан шингэн нь гадны даралтыг өөрчлөхгүйгээр зүг бүртдамжуулна. /1 оноо/

- A. жигд B. жигд биш C. өөр өөр D. даралт

3. Битүү саванд агуулагдсан хий ханандаа ямагт даралтбайдаг. /1 оноо/


- A. учруулж B. учруулдаггүй C. өөр өөр D. даралт

4. Физикт биесийн татах , түлхэх үйлчлэлийн их багын хэмжээг юуг гэсэн физик хэмжигдэхүүнээр илэрхийлдэг вэ? /1 оноо/

- A. Хүч B. Хурдатгал C. Харимхай бус деформац D. Деформац

5. F хүчний мөр аль вэ? /1 оноо/

- A. DB B. AO C. OB D. CO



6. Биеийн шилжсэн зайг харгалзах хугацаанд харьцуулж биеийн юуг олдог вэ? /1 оноо/

- A. зам B. хурд C. хугацаа D. масс

7. Биеийн хөдөлгөөний эхний ба эцсийн байрлалыг холбосон чиглэлтэй хэрчимийггэнэ. /1 оноо/

- A. Зам B. Траектори C. Шилжилт D. Хурд E. Хурдатгал

8. Дараах томъёонуудаас биеийн хурднаас хамаарсан энергийг олох томъёог сонгоно уу. /1 оноо/

- A. $E = \frac{kx^2}{2}$ B. $E = mgh$ C. $E = \frac{mv^2}{2}$ D. $N = \frac{A}{t}$ E. $A = F \cdot h$

9. Цахилгаан гүйдлийн их багыг илэрхийлдэг физик хэмжигдэхүүнийг нэрлэнэ үү? /1 оноо/

- A. Цэнэг B. Хүчдэл C. Гүйдлийн хүч D. Эсэргүүцэл

10. Ороомгоор гүйдэл гүйлгэхэд соронзон чанартай болдгийг бид мэднэ. Ороомгийн ороодсын тоог олон болгоход соронзон татах чадвар нь өөрчлөгдөх үү. /1 оноо/

- A. Ихэснэ B. Багасна C. Өөрчлөгдөхгүй D. Соронзон чанараа алдана

11. Энергийн нэгжийг нэрлэнэ үү? /1 оноо/

- A. Вт B. Ж C. Па D. Н

12. Хий, шингэний урсгалаар бодис зөөгдөхийн хамт энерги зөөгдөхийг-р дулаан шилжих гэнэ. /1 оноо/

- A. Дулаан дамжуулал B. Конвекц C. Цацаргалт D. Бүгд

13. Хүч, даралт, талбай зэрэг ойлголтыг ашиглан өгүүлбэрийн дутууг гүйцээнэ үү. /2 оноо/

Нарийн хадаасбагатай учир.....их учруулна.

- A. даралт, хүч
B. хүч, талбай
C. хүч, даралт
D. талбай, даралт

14. 20м гүнд далайн усны учруулах даралтыг м.у.б-аар илэрхийлнэ үү. /2 оноо/

- A. 2000 мм м.у.б B. 1520 мм м.у.б C. 100 мм м.у.б D. 1545 мм м.у.б

15. Куб хэлбэртэй бие хийгээр дүүрэв. Нэг ханан дээр нь 5Па даралт учруулбал бусад ханан дээр ямар даралт учрах вэ? /2 оноо/


- A. 10Па B. 2.5Па C. 5Па D. 30Па

16. Хүчний үйлчлэл зогсоход бие анхны хэлбэртэй буцаж орж байвал харимхай деформац, гажсан чигтээ үлдвэлгэнэ. /2 оноо/

- A. Харимхай деформац B. Харимхай бус деформац C. Биеийн масс D. Хүчний мөр


17. Зурагт үзүүлсэн хүчнүүдийн нийлбэр хүчийг олоорой. /2 оноо/

- A. 11Н B. 7Н C. 6Н D. 9Н



18. $F_1 \cdot l_1 = F_2 \cdot l_2$ энэ томъёо юуг илэрхийлдэг вэ? /2 оноо/


- A. Хүчийг B. Мөрийг C. Хөшүүргийн тэнцвэр
Хөшүүрэг



D.

19. Хөшүүргийн төгсгөлүүдэд 2Н (урт мөр) ба 6Н (богино мөр) жинтэй ачаа тавихад тэнцвэрт оршино. Хөшүүргийн богино мөр 4см бол урт мөрийг олно оноо/

- A. 1.3см B. 10см C. 8см D. 12см



уу. /2

20. Зурагт үзүүлсэн эргэвчээр ачааг жигд өргөх хүчийг олно уу? /2 оноо/

- A. 0.1Н B. 1Н C. 100Н D. 10Н


21. $36 \frac{км}{ц}$ хэдэн $\frac{м}{с}$ -тэй тэнцүү вэ? /2 оноо/

- A. $36 \frac{м}{с}$ B. $3,6 \frac{м}{с}$ C. $10 \frac{м}{с}$ D. $20 \frac{м}{с}$

22. $40 \frac{м}{с}$ -ийг уггачлан унших нь аль вэ? /2 оноо/

- A. 40с хугацаанд 40м зам явна. B. 1с хугацаанд 40м зам явна.
C. 40м замыг 40с хугацаанд явна. D. уггачлан уншиж болохгүй.

23. Доорх графикуудаас аль нь жигд удаашрах хөдөлгөөнийг илэрхийлэх вэ? /2 оноо/



- A. а
B. б
C. в
D. г
E. д
24. Биеийн хөдөлгөөн улам саарч

ижил хугацаанд туулах зам нь богиносно. Ямар хөдөлгөөн хийж байна вэ? /2 оноо/

- A. жигд B. удаашрах C. хурдсах D. хувьсах

25. Хөдөлгөөнийголохдоо биеийн туулсан бүх замыг харгалзах хугацаанд нь хувааж олно. /2 оноо/

- A. Хурд B. хугацаа C. зам D. дундаж хурд

26. Биеийн хурднаас хамаарсан энергийг хөдөлгөөний энерги буюугэнэ. /2 оноо/

- A. Хөдөлгөөний энерги B. Потенциал энерги
C. Кинетик энерги D. Бүтэн энерги

27. Оргил 5кг ачааг 2м өндөрт гаргасан. Ямар энерги зарцуулсан бэ? Потенциал энергийг олно уу. /2 оноо/

- A. 100Ж B. 10Ж C. 50Ж D. 2.5Ж

28. Дараах томъёонуудаас механик ажлыг олох томъёог сонгоно уу. /1 оноо/

- A. $E = \frac{kx^2}{2}$ B. $E = mgh$ C. $E = \frac{mv^2}{2}$ D. $N = \frac{A}{t}$ E. $A = F \cdot S$

29. Нэгж хугацаанд урсан өнгөрөх цэнэгийн хэмжээггэнэ. /1 оноо/

- A. Хүчдэл B. Эсэргүүцэл C. Гүйдлийн хүч D. Чадал

30. Гар утасны дэргэд соронзон зүү байрлуулсан үед утас дуугарахад зүү хазайдгийн учир юу вэ? /2 оноо/

- A. Утасны дуу чимээ гарснаас B. Утас чичирснээс
C. Гүйдлийн соронзон орноос D. Цахилгаан орноос

31. Хэрэв шингэнт машины том бүлүүрийн талбай $500см^2$, бага бүлүүрийн талбай $5см^2$ бөгөөд бага бүлүүр дээр 100Н хүч үйлчилж байвал том бүлүүр дээр ямар хүч үйлчлэх вэ? /2 оноо/

- A. 20кН B. 10кН C. 5кН D. 2кН

32. Материал цэгийн хөдөлгөөний графикаас хурдатгал олно уу? /2 оноо/

- A. $50 \frac{м}{с^2}$ B. $7.2 \frac{м}{с^2}$ C. $2 \frac{м}{с^2}$ D. $10 \frac{м}{с^2}$

33. 300г масстай чулууг 10м/с хурдтай шидэв. Шидсэн агшинд чулууны кинетик ямар байх вэ? /2 оноо/

- A. 15Ж B. 1500Ж C. 1.5Ж D. 15000Ж

34. Сурагч 5кг масстай цүнхийг 100см өндөрт өргөсөн бол гүйцэтгэх ажлыг олно уу. /2 оноо/

- A. 500Ж B. 50Ж C. 5000Ж D. 5Ж E. 25Ж

35. Гар чийдэнгээр 10с-д 2Кл цэнэг урссан бол гүйдлийн хүч нь ямар байх вэ? /2 оноо/

- A. 2А B. 20А C. 0.2А D. 10А


36. ЭНЕРГИ-хадгалагддаг, зөөгддөг, хувирдаг,..... /1 оноо/

Асуултын оронд тохирох зөв хариултыг сонгоно уу?

- A. Устаж алга болдог B. Шинээр бий болдог
C. Үнэ цэнээ алддаг D. Өөр дүрсэд шилждэг.

37. Дараах багажуудаас аль нь температурыг хэмжих вэ? /1 оноо/

- A. Динамометр B. Манометр C. Спидометр D. Термометр



ЗАДГАЙ ДААЛГАВАР-3:

1. Хөшүүргийн тэнцвэрийн нөхцөлийг ашиглаж хүснэгтийн дутуу нүдийг бөглөнө үү. Хэмжилт бүрийн хувьд хөшүүргийн тулах цэгт ямар хүч үйлчилж байгаа вэ? / 4 оноо/

№	F_1	Зүүн мөр, l_1	F_2	Баруун мөр, l_2
1	100Н	?	20Н	25см
2	10кН	18м	?	2м
3	?	15см	300Н	75см
4	200Н	2м	?	4м

2. Хүн 2ц явахдаа 10000 алхам хийж алхам бүрт 40Ж ажил хийсэн бол явахдаа ямар хэмжээний чадал гаргасан бэ? /4 оноо/

3. 6Ом, 2Ом, 8Ом эсэргүүцлүүдийг зурагт үзүүлснээр холбож 2А гүйдэл гүйлгэсэн бол ерөнхий хүчдэл ямар байх вэ? /4 оноо/

